

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Газар тариалангийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Баттөмөр Оюунтунгалаг
2025 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
1	2	3	4	5	6	7	
1.1. Тариалангийн нийт эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, газар тариалангийн хүрсэн түвшинг тогтворжуулан хөгжүүлнэ							
1	Үр тариа тос тэжээлийн тариалангийн төлөвлөгөөг хэрэгжүүлэн зохион байгуулах	Тариалах талбай, хураан авах ургацын хэмжээ (га, цн)	Үр тариа 3957 га Тэжээл 280 га Тос 832 га	Тариалах талбай, хураан авах ургацын төлөвлөгөө даалгаврыг сум, аж ахуйн нэгж, иргэнээр, таримлын төрөл тус бүрээр задлан эзэнжүүлж хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулсан байна	Аймгийн 2025 онд тариалах талбай хураан авах ургацын төлөвлөгөөг Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэ онд аймгийн хэмжээнд нийт 4300 га талбайд үр тариа, тэжээлийн ургамал тариалахаар төлөвлөсөн. 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар үр тариа 3663 га, тосны ургамал 746 га, тэжээлийн ургамал 337 га буюу нийт 4746 га талбайд тариалалт хийж гүйцэтгэл 100 хувьтай байна Хавсралт: 2 файл	3-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар	100%
2	Өрхийн тариаланчдыг дэмжих төлөвлөгөөний	Төлөвлөгөөний хэрэгжилтээр	97 хувьтай хэрэгжсэн	80 хувь	Өрхийн тариалалтыг дэмжих зорилгоор аймгийн Засаг даргаар 2025 онд өрхийн	4-р сар, 5-р сар,	80%

	хэрэгжилтийг ажиллана	ханган				тариалалтыг дэмжих хөтөлбөрийн төлөвлөгөөг батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төлөвлөгөөнд нийт 9 арга хэмжээ төлөвлөсөн. Хөтөлбөрийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Үүнд: 1. Төмс, хүнсний ногооны үрийн дэмжлэгт Баян-Өндөр сумын 500 өрхийг хамруулан, сургалт арга зүйгээр хангасан. Дэмжлэгт хамрагдсан өрхүүдэд 250 м.кв талбайд тарихаар тооцож үр олгосон нь нийт 12.5 га талбайд төмс, хүнсний ногоо тариалсан. 2. Хүлэмжийн тариалалтыг дэмжих зорилгоор орон нутгийн төсвөөс 6*10 м харьцаатай 50 ширхэг хүлэмжийг худалдан авч, олгох ажлыг зохион байгуулан ажиллаж байна. 3. Жаргалант сум нь төмс, хүнсний ногооны үр шинэчлэх зорилгоор сумын төсвөөс 79.1 сая төгрөг шийдвэрлэсэн. Тус ажлын хүрээнд төмсний үр 30 тн, шар луувангийн үр 100 кг, шар манжингийн үр 50 кг, хүрэн манжингийн үр 50 кг, урт сонгины үр 10 кг-ыг 80 хувийн хөнгөлөлттэй үнээр иргэдэд олгосон. Үүний үр дүнд 25 га талбайд төмс, 32 га талбайд шар лууван, 17 га талбайд шар манжин, 10 га талбайд хүрэн манжин, 2 га талбайд урт сонгино тарих үрээр дэмжсэн.	7-р сар, 9-р сар, 10-р сар	
3	Хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх, хөрөнгө оруулалт, санхүүгийн	Хамгаалагдсан хөрсний тариалалт, хураан авсан	Нийт 273 иргэн, 4 аж ахуйн нэгж 30.3 мянган.м.кв	Хамгаалагдсан хөрсний тариалалтыг	Хүлэмжийн тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор орон нутгийн төсвийн хөрөнгөөр 6*10 м харьцаатай 50 ширхэг хүлэмж худалдан авч олгох ажлыг зохион	Хавсралт: 1 файл	5-р сар, 6-р сар, 8-р сар,	50%

	дэмжлэг үзүүлэх.	ургацын хэмжээ /га, тн/	хүлэмжийн талбайгаас 332 тн ургац авсан.	нэмэгдүүлсэн	байгуулахаар бэлтгэл ханган ажиллаж байна. Үүний үр дүнд хүлэмжийн талбай 3000 м.кв нэмэгдэх боломж бүрдсэн.	9-р сар	
4	Тариалангийн талбайн хөрс хамгаалах арга хэмжээний хүрээнд төмөр бетон шонг суурьлуулах ажиллагааг эрчимжүүлж гэрээний дагуу тайланг нэгтгэн ирүүлэх	1.Шонг бүрэн суурьлуулж хашаажуулсан байна 2.Ойн зурвас байгуулсан байна	24000 ширхэг шон нийлүүлсэн	Шонг бүрэн суурьлуулж хашаажуулсан байна	Тариалангийн талбайн хөрс хамгаалах арга хэмжээний хүрээнд төмөр бетон шонг тариаланчдын эзэмшилд шилжүүлж, ашиглалтын гэрээ байгуулсан. Гэрээг 9 аж ахуйн нэгж 3 иргэнтэй байгуулсан. Тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүд төмөр бетон шон суурилуулах ажлыг хийж гүйцэтгэж байна. Үүний үр дүнд нийт 4100 га талбайг хашиж хамгаалсан байна. Хавсралт: 2 файл	6-р сар, 8-р сар	50%
5	Төмс, хүнсний ногооны усалгаатай талбайн хэмжээг нэмэгдүүлэх, техник технологийн шинэчлэлт хийх	Усалгаатай талбайн нэмэгдсэн хэмжээ га	16 га	-	Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны хэрэгжүүлж буй "Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй" төслийн хүрээнд услалтын системийг шинэчлэн сайжруулах төслийн 2-р шатанд Хангал голын дагуу төмс, хүнсний ногооны 700 га талбайн усалгааны нөхцөл сайжруулах ажлыг хамруулахаар шийдвэрлэсэн. Тус ажлын даалгаврын төслийг боловсруулах ажлын хэсэгтэй хамтран Жаргалант сумын төсөл хэрэгжүүлэх газар дээр нь ажиллаж, холбогдох албан тушаалтантай уулзан санал солилцон, шаардлагатай судалгаа, мэдээллээр ханган ажилласан. Тус төсөл хэрэгжүүлэхээр ажлын даалгавар, зураг төсөв боловсруулах ажил хийгдэж байна. Хавсралт: 1 файл	5-р сар, 6-р сар, 9-р сар	50%

6	Төмс, хүнсний ногооны механикжуулалтыг нэмэгдүүлэхээр шинээр техник, тоног төхөөрөмж худалдан авсан ногоочин иргэн, аж ахуйн нэгжид техникийн үнийн 50 хувийн хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээг plant.mofa.gov.mn газар тариалангийн цахим системээр хэрэгжүүлэхийг сурталчилж хамруулах	Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжлэгт хамруулсан байна.	-	-	Төмс, хүнсний ногооны механикжуулалтыг нэмэгдүүлэхээр шинээр техник, тоног төхөөрөмж худалдан авсан ногоочин иргэн, аж ахуйн нэгжид техникийн үнийн 50 хувийн хөнгөлөлт үзүүлэх арга хэмжээг plant.mofa.gov.mn газар тариалангийн цахим системээр хэрэгжүүлэхийг сурталчлах ажлыг 3 удаа зохион байгуулсан. Үүнд: 1. Байгууллагын нээлттэй хаалганы өдөр 2. Аймгийн малчил тариаланчдын зөвөлгөөн 3. Өрхийн тариаланд чыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулсан сургалтаар нийт 300 гаруй иргэнд мэдээлэл өгч, мэргэжил арга зүйгээр хангасан.	5-р сар, 8-р сар	50%
7	Жимс жимсгэний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхийг дэмжиж ажиллах	Шинээр нэмэгдсэн жимс, жимсгэний талбай, хураан авсан ургац	Жимс, жимсгэний талбай шинээр нэмэгдээгүй, 42,9 тн	-	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих аймгийн тэргүүлэх чиглэлд Агро ойн аж ахуйн чиглэлийг оруулсан. Баян-Өндөр сумын 1 аж ахуйн нэгж Агро ойн аж ахуйн чиглэлээр Жижиг дунд үйлдвэрийн дэмжих сангийн зээлд хамрагдахаар хүсэлт илгээсэн. Одоогоор судлагдах шатандаа явж байна.	5-р сар, 8-р сар, 10-р сар	30%
1.3. Тариалангийн газрыг зүй зохистой ашиглах, хөрс хамгаалах, сайжруулах							
8	Тариалалт, уринш боловсруулалт, ургац хураалтыг технологийн хугацаанд гүйцэтгэх техникийн хангамж, ажиллах хүчний хангамж, шатах тослох	ариалах талбай, хураан авах ургацын хэмжээ (га, цн)	3841 га-аас 10097 тонн үр тариа 167 га-аас 1941 тонн төмс 474 га-аас 12149 тонн хүнсний ногоо	Тариалах талбай, хураан авах ургацын төлөвлөгөө даалгаврыг сум, аж ахуйн нэгж, иргэнээр,	Хаврын тариалалтын ажлыг технологийн хугацаанд чанартай зохион байгуулах, тариалалтын чанарыг соёололтоор хүлээн авах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг аймгийн Засаг даргын 2025 он А/393 дугаар захирамжаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллаж	5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар	50%

материалын нөөц бүрдүүлэх, ургацыг хамгаалах, ургацын зам засвар зэрэг ажлуудыг гүйцэтгэхэд шаардлагатай арга хэмжээг зохион байгуулах		832 га-аас 284 тонн тосны ургамал 280 га-аас 1294 тонн тэжээлийн ургамал	таримлын тус төрөл бүрээр задлан эзэнжүүлж хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулсан байна	байна. Мөн хаврын тариалалтад шаардлагатай үрийн мэдээ, тариалалтад ажиллах техникийн бэлэн байдлын мэдээг гарган ХХҮҮХҮЯ-д хүргүүлсэн. Мөн тэжээлийн ургамал тариалах иргэн, аж ахуйн нэгжийг дэмжих зорилгоор Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас тэжээлийн ургамлын үрийг 30 хувийн урьдчилгаатайгаар олгохоор шийдвэрлэсэн. Тус ажлын хүрээнд тэжээлийн ургамал тариалах 1 аж ахуйн нэгж, 3 иргэний 24,5 га талбайд тариалалт хийхэд шаардлагатай 4.4 тн үрийн захиалгыг холбогдох газар хүргүүлсэн. Тариалалтын мэдээ: Аймгийн хэмжээнд энэ онд нийт 5156 га талбайд тариалалт хийхээр төлөвлөсөн. Үр тариа 3663 га үүнээс улаан буудай 3546 га, бусад 120 га, төмс 145 га, хүнсний ногоо 268 га, тосны ургамал 746 га, тэжээлийн ургамал 337 га нийт 5159 га талбайд тариалалт хийж, 100.0 хувьтай байна.		
--	--	--	---	--	--	--

Хавсралт: 1 файл

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ							
№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан	Биелэлтийн

	1	2	3	4	5	хугаца	хувь
						6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Газар тариалангийн салбарын Зөвлөгөөн сургалт арга хэмжээнд тогтмол хамрагдсан байна.	Мэдлэг чадвараа дээшлүүлэн, хөгжүүлэх	Улсын зөвлөгөөн, арга хэмжээнд 2 удаа, мэдлэг чадвар дээшлүүлэх сургалтад 2 удаа хмарагдсан	Газар тариалангийн салбарын Зөвлөгөөн сургалт арга хэмжээнд тогтмол хамрагдсан байна.	Мэдлэг чадвар дээшлүүлэх зорилгоор дараах сургалтуудад хамрагдсан. Үүнд: 1. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Ургамал, газар тариалангийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгээс зохион байгуулсан "Хөрсний үржил шим, хүнсний ногооны таримлын нэр төрлийг нэмэгдүүлэх" чиглэлийн сургалтад хамрагдсан. 2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас "Хөрсний үржил шим, хүнсний ногооны таримлын нэр төрлийг нэмэгдүүлэх туршлага, зорилт" сэдэвт сургалтад оролцсон. 2. Монгол Улсын засгийн газраас тариалангийн үйлдвэрлэлд дэвшилтэт техник технологийг нэвтрүүлж, ухаалаг технологид суурилсан газар тариаланг хөгжүүлэх, хөрсний үржил шимийг хамгаалж, сайжруулах зорилгоор "Атар-4 тариалангийн тогтвортой хөгжлийн аян"-ыг 2025 оны 02 дугаар сарын 01-ий өдрөөс эхлэн 4 жилийн хугацаатай өрнүүлэхээр шийдвэрлэсэн. Аяны хүрээнд Дархан-Уул аймагт зохион байгуулагдах газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийн салбар хуралдаан болон "АТРЫН	4-р сар, 8-р сар, 10-р сар	100%

					ДӨРӨВДҮГЭЭР АЯН" хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн улсын зөвлөгөөнд орон нутгаас нийт 22 иргэн, аж ахуйн нэгжийг нэгдсэн удирдлагаар ханган оролцсон. 3. Засгийн газрын 2025 он 47 дугаар тогтоолоор "Аян өрнүүлэх тухай" баталсан. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас зохион байгуулсан "Атрын дөрөвдүгээр аян" хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн улсын зөвлөгөөнд оролцсон.		
--	--	--	--	--	--	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

Газар тариалангийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Баттөмөр Оюунтунгалаг /....../

2025.06.10

Огноо: